



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

09.14 - 09.18



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт компаниудын нэгдлийн тухай болон COVID-19-ийн вакцинтай холбоотой эерэг мэдээлэл гарсан ч Холбооны Нөөцийн Сангийн мөнгөний бодлогын арга хэмжээнүүдийн эдийн засгийн сэргэлтэд үзүүлэх нөлөө буурч байгаатай холбоотой АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй хаагдлаа. Хөрөнгө оруулагчид сүүлийн саруудад зах зээлийг тэргүүлж байсан интернет болон харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудаас хөрөнгөө татаж эхэлсэнтэй холбоотой үнэ цэнийн (Value stocks) болон зах зээлийн үнэлгээ багатай (small-caps) компаниуд хамгийн их өсөлттэй байлаа. АНУ-ын дотоодын газрын тосны нөөц огцом буурсан болон Саудын Арабаас газрын тос экспортлогч орнуудыг олборлолтоо бууруулахыг шаардсантай холбоотой S&P 500 индексийн сагсанд багтах эрчим хүчний салбар компаниуд хамгийн их өсөлттэй байлаа. Харин Холбооны Худалдааны Хороо Facebook компанийн эсрэг монополийн эсрэг ажиллагаа бэлтгэж байна гэсэн мэдээллээс үүдэн харилцаа холбооны салбар хамгийн их бууралттай байлаа.

Европ: Коронавирусийн шинэ тохиолдлын тоо нэмэгдэж байгаа ч Европын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь агуулах STOXX Europe 600 индекс 0.22%-аар өсөлттэй хаагдлаа. Гэхдээ, бусад томоохон индексүүд болох Xetra DAX индекс 0.66%-аар, FTSE MIB индекс 1.49%-аар, CAC 40 индекс 1.11%-аар, FTSE 100 индекс 0.42%-аар тус тус буурсан байна. STOXX Europe 50, STOXX Europe 600, FTSE 100, DAX болон Испани улсын IBEX индексийн сагс Баасан гарагт шинэчлэгдэх ба Европын зах зээлийн Баасан гаргийн хаалтын дараанаас өөрчлөлт орсон индексүүд тооцогдож эхлэх юм.

Шинжээчдийн хүлээлтийн дагуу Английн Төв Банк (BoE) мөнгөний бодлогын хүүгийн түвшнийг хэвээр үлдээлээ. Гэсэн хэдий ч мөнгөний бодлого боловсруулагчид, Төв банк коронавирусийн шинэ тохиолдлууд нэмэгдэж байгаа, засгийн газрын ажлын байрыг дэмжих хөтөлбөр дууссан болон Brexit-тэй холбоотой эрсдэлүүд эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлж эхэлбэл цаашид арга хэмжээ авахад бэлэн байгаагаа илэрхийлжээ.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индекс холимог үзүүлэлттэй хаагдлаа. Nikkei 225 индекс 46 нэгжээр буюу 0.2%-аар буурч 23,360.30 нэгж хүрч хаагдсан нь оны эхэн үетэй харьцуулахад 1.3%-аар буурсан үзүүлэлт юм. Харин Япон улсын хөрөнгийн зах зээлийг бүхэлд нь илтгэгч TOPIX индексүүд өсөлттэй хаагджээ. Иений ханш энэ долоо хоногт ам.долларын эсрэг чангарсан ба Баасан гарагт 1 ам.доллар 105 иенээс багаар арилжаалагджээ.

БНХАУ: БНХАУ-ын томоохон эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг гарсан ба эдийн засгийг идэвхжүүлэх хөтөлбөрүүдийг дахин хэрэгжүүлэх магадлалтай байгаагаас үүдэн БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. Shanghai Composite индекс болон CSI 300 индексүүд өнгөрсөн хоёр долоо хоногт дараалан буурсан алдагдлаа нөхөж энэ долоо хоногт 2.4%-аар өссөн байна. Эдийн засгийн үзүүлэлтүүд эерэг гарсан ч бондын зах зээл дээр БНХАУ-ын 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны өгөөж тогтвортой байлаа. Харин ам.долларын эсрэг юанийн ханш наймдах долоо хоногтоо дараалан чангарсан байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	17,379.43	2.85% ▲
Dow Jones	АНУ	27,657.42	-0.03% ▼
S&P 500	АНУ	3,319.47	-0.64% ▼
Nasdaq	АНУ	10,793.28	-0.56% ▼
S&P/TSX	Канад	16,198.97	-0.14% ▼
FTSE 100	Их Британи	6,007.05	-0.42% ▼
S&P/ASX 200	Австрали	5,864.50	0.09% ▲
Nikkei 225	Япон	23,319.37	-0.37% ▼
Hang Seng	Хонг Конг	24,455.41	-0.20% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.48
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.15
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.04
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	103.74
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	101.31
DBM' 2023	USD	7.250%	105.46
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.62

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.156	0.02 ▲
Libor 3M	0.225	-0.10 ▼
Libor 6M	0.275	-0.02 ▼
Libor 1YR	0.374	-0.10 ▼
US 2YR Bond	0.139	0.08 ▲
US 3YR Bond	0.162	0.09 ▲
US 5YR Bond	0.282	0.13 ▲
US 10YR Bond	0.694	0.05 ▲

Валютын ханш	2020.09.18	Өөрчлөлт
USD	2,854.35	-0.01% ▼
CNY	422.24	1.12% ▲
EUR	3,381.98	0.10% ▲
RUB	38.03	-0.21% ▼
KRW	2.46	2.07% ▲
JPY	27.29	1.56% ▲
CAD	2,168.46	0.05% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,950.86	0.53% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	26.78	0.20% ▲
Зэс	USD/lb.	311.60	2.52% ▲
Нүүрс	USD/MT	59.10	7.45% ▲
WTI газрын тос	USD/bbl.	41.11	10.13% ▲
Brent газрын тос	USD/bbl.	43.15	8.34% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.05	-9.69% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.VIII	2.10%
Бодлогын хүү	2020.VIII	8.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.VIII	8.73%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	10.84%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.VIII	4.13%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.VIII	16.93%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.VIII	10.44%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 49 компанийн 416.5 сая төгрөгийн 3,508,406 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Ард санхүүгийн нэгдэл” /MSE: AARD/ компанийн хувьцаа 24.38%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,306.00 төгрөг хүрч хаагдсан бол “Оллоо” /MSE: OLL/ компанийн хувьцаа 15.51%-аар буурч 53.14 төгрөгт хүрч хаагдлаа.

Компанийн бондын хоёрдогч зах зээл дээр “Лэндмн ББСБ” ХК-ийн 6.3 сая төгрөгийн 62 ширхэг үнэт цаас арилжаалагдав

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

9-р сарын 18-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,605.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 индекс 17,379.43 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.85% -аар өссөн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	LNBO-BD-19/06/21-C0008-17	62	6,250,000	100,000	101,000	52	17%

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	422.7	
Зах зээлийн үнэлгээ	2,605,182.4	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	17,379.43	2.85% ▲
MSE I индекс	8,300.77	0.69% ▲
MSE II индекс	7,425.31	0.98% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Монос хүнс	2,214,584	153,216,352
Ард санхүүгийн нэгдэл	120,647	134,052,022
АПУ	56,660	32,567,809
Лэндмн ББСБ	606,676	18,250,023
Инвекор ББСБ	5,918	15,890,526

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Ард санхүүгийн нэгдэл	1,306.00	24.38% ▲
Жуулчин дюти фрийд	77,000.00	23.39% ▲
Баянгол зочид буудал	28,800.00	15.20% ▲
Хэрлэн хивс	42.00	13.51% ▲
БиДиСек	850.00	13.33% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Оллоо	53.14	-15.51% ▼
Сэлэнгэ сүрэг	4,250.00	-15.00% ▼
Хишиг уул	500.00	-13.79% ▼
Монинжбар	99.00	-11.60% ▼
Махимпекс	2,678.00	-10.70% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Голомт Капитал	266,396,342
БиДиСек	91,596,088
Ард Секюритиз	84,662,916
Бумбат-Алтай	81,558,295
Гаули	73,601,172

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	572.90	609,669.61
Таван толгой	5,990.00	315,464.55
МИК холдинг	12,800.00	265,079.30
Инвекор ББСБ	2,691.00	193,019.83
Говь	199.41	155,562.23

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.08.06-НД ОЛГОВ
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.07.09-НД ОЛГОВ
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.09.07-НД ОЛГОВ
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.07.30-НД ОЛГОВ
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.07.08-НД ОЛГОВ
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.07.31-НД ОЛГОВ
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.07.21-НД ОЛГОВ
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголын Хөрөнгийн Биржид 3 компани нийт 16.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт босгохоор холбогдох материалаа хүргүүлсэн бөгөөд биржийн зүгээс хяналт, шалгалтын ажил хийж байна. Эдгээрт компанийн IPO, компанийн бонд болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах төслүүд багтаж байгаа аж.

Харин МХБ-ийн I ангилалд бүртгэлтэй “Сүү” /MSE:SUU/ ХК нэмэлт хувьцаа гарган 18.5 тэрбум, “Үндэсний хувьчлалтын сан” Хаалттай хамтын сан 5 тэрбум төгрөг босгохоор холбогдох зөвшөөрлөө аван ажиллаж байна.

Эх сурвалж: MarketInfo.mn

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Тэндем инвест ББСБ” /MSE: VIK/ ХК шүүхэд нэхэмжлэгч (хариуцагч)-ээр оролцож буй байдал.

Компани Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443-р тогтоолоор баталсан Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журмын 3.2-д Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна гэж заасны дагуу тус журмын 3.2.2.11-д Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцохтой холбоотой мэдээллийг үүгээр хүргүүлж байна.

Компани 2020 оны 9-р сарын 14-ны өдрийн байдлаар шүүхэд нэхэмжлэгчээр оролцож буй мэдээлэл:

№	ТӨРӨЛ	ТОО	ҮНИЙН ДҮН
1	НЭХЭМЖЛЭЛ	1	38,572,127 ТӨГРӨГ
2	ШҮҮЖИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГАА	2	81,937,223 ТӨГРӨГ

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Таван толгой” /MSE: TTL/ ХК 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа нийтэллээ.

Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд бүртгэлтэй “Таван толгой” /MSE: TTL/ ХК 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа 2020 оны 9-р сарын 16-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулсан байна.

Тус компани 2020 оны эхний хагас жилд 1,180.1 мянган тонн нүүрс олборлож, 831.7 мянган тонн нүүрс борлуулсан ба нийт 91.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 3.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 9.3%-аар буюу 120.2 мянган тонноор, нүүрс борлуулалт 25.1%-аар буюу 278.7 мянган тонноор, борлуулалтын орлого 25.8%-аар буюу 32.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Стандарт агрикалчер групп” /MSE: SOH/ ХК 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа нийтэллээ.

Монголын Хөрөнгийн Биржийн III ангилалд бүртгэлтэй “Стандарт агрикалчер групп” /MSE: SOH/ ХК 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа 2020 оны 9-р сарын 16-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулсан байна.

“Стандарт агрикалчер групп” /MSE: SOH/ ХК нь нь газар тариалан, бизнесийн зөвлөгөө өгөх, фермерийн аж ахуй, гадаад худалдаа зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулдаг. “Стандарт агрикалчер групп” /MSE: SOH/ ХК-ийн гүйцэтгэх захирлаар Монгол улсын иргэн Лхагва овогтой Золбаяр нь 2015.11.20 өдрөөс хойш ажиллаж байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Өндөрхаан” /MSE: ONH/ ХК 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны мэдээлэл.

Монголын Хөрөнгийн Биржийн III ангилалд бүртгэлтэй “Өндөрхаан” /MSE: ONH/ ХК 2020 оны эхний хагас жилд үйл ажиллагаа явуулаагүй тухай мэдээллээ Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулсан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Стандарт проперти групп” /MSE: BBD/ ХК 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны мэдээлэл.

Монголын Хөрөнгийн Биржийн III ангилалд бүртгэлтэй “Стандарт проперти групп” /MSE: BBD/ ХК 2020 оны эхний хагас жилд үйл ажиллагаа явуулаагүй тухай мэдээллээ Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршуулсан байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 оны 9-р сарын 14-ний өдөр хуралдан (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 8 хувьд хүргэх; (2) урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргалаа. Энэхүү шийдвэр нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд банкны салбараас эдийн засгийн бодит секторт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн болно. Тухайн шийдвэр, арга хэмжээ нь инфляцын зорилтыг хангаж, эдийн засгийн уналтыг сааруулан, улмаар сэргэлтийг дэмжинэ.

Эх сурвалж: Монголбанк



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 8-р сарын эцэст 21.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.9 (4.4%) их наяд төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 1.7 (58.6%) их наяд төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 383.4 (3.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Бага мөнгө (M1) 2020 оны 8-р сарын эцэст 3.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 76.3 (2.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 549.5 (14.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Бага мөнгө (M1)-ний 2.7 (80.8%) их наяд төгрөг нь төгрөгийн харилцах, 0.7 (19.2%) их наяд төгрөг нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө байна.

Бараг мөнгө 2020 оны 8-р сарын эцэст 18.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 5.9 (0.03%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.5 (8.8%) их наяд төгрөгөөр өссөн байна. Бараг мөнгөний 11.2 (62.4%) их наяд төгрөг нь төгрөгийн хадгаламж, 4.7 (25.9%) их наяд төгрөг нь валютын хадгаламж, 2.1 (11.7%) их наяд төгрөг нь валютын харилцах байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 8-р сарын эцэст 928.2 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.9 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.5 (0.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Гадаад худалдааны тэнцэл 2019 оны эхний 8 сард 1.3 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 270.2 сая америк доллароор буурч, 1.0 тэрбум америк долларын ашигтай байна.

2020 оны эхний 8 сарын байдлаар БНХАУ-тай 4.4 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 55.8 хувийг эзэлж байна.

БНХАУ-д гаргасан бараа бүтээгдэхүүний 35.1 хувийг чулуун нүүрс, 31.9 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон барааны 99.8 хувийг, Сингапур

улсад экспортолсон барааны 65.9 хувийг, Их Британи улсад экспортолсон барааны 59.2 хувийг алтны экспорт эзэлж байна.

Экспорт өмнөх оны мөн үеэс 908.2 сая америк доллароор буурахад зэсийн баяжмалын экспорт 317.7 сая америк доллар, нүүрсний экспорт 967.7 сая америк доллароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Алтны экспорт өмнөх оны мөн үеэс 802.2 сая америк доллар буюу 3.3 дахин өсжээ.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.